



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2021/116/СТА/ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймгийн Төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цэням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт/Эх хувь/.....	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	18
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г ЖИНСТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М. БИБИШ ТАНАА 7

2021.02.25 № 2/173

танай _____ -ны № _____ -г

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** 7

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 23 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь "Хязгаарлалттай" дүгнэлт өгөх үндэслэл болно. **Үүнд:**

2021 А4 ТООТ

• 005020234

- Сургуулийн захирлын 2020.12.08-ны өдрийн А/103 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь хөрөнгийг тоолсон гэх боловч тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо бодсон акт үйлдээгүй.

- Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй тайлант онд нярвын хувийн харилцах дансаар 13165.0 мянган төгрөг дамжуулж хөрөнгө худалдаж авсан Е баримт болон ачаа тээврийн зардал төлсөн баримт байхгүй зэрэг зөрчлийг дахин давтан гаргасан.

- Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулалгүйгээр халаалтын зардлаас 8760.0 мянган төгрөгийн хөрөнгө, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 6800.0 мянган төгрөгийн шатах тослох материал, үдийн цайны зардлаас 5200.0 мянган төгрөгийн шатах тослох материал тус тус бэлтгэсэн байна.

Дээрх алдаа зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар 16.5.5."Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "Үнэн зөв байдал", "Иж бүрэн байх", "Оршин байх", "Үнэлгээ" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2.1. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,235,148.09	71,267,348.09
33	АВЛАГА	1,618,698.09	12,568,698.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,618,698.09	2,618,698.09
335	Бусад авлага	00.00	9,950,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,950,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,616,450.00	58,698,650.00
351	Түүхий эд материал	33,039,300.00	49,556,750.00
35110	Тусгай зориулалттай материал	33,039,300.00	46,199,300.00
35130	Эм боох материал	00.00	3,357,450.00
354	Хангамжийн материал	9,577,150.00	9,141,900.00
35410	Бичиг хэргийн материал	808,000.00	3,101,900.00
35420	Аж ахуйн материал	1,607,400.00	5,996,600.00
35460	Хүнсний материал	7,161,750.00	43,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	286,760,701.06	1,751,926,896.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	286,760,701.06	1,751,926,896.37
392	Биет хөрөнгө	253,684,242.63	1,718,906,937.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	200,429,815.50	1,623,309,815.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-33,688,291.00	-62,259,661.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,383,846.95	119,458,552.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,483,501.71	-66,636,779.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,042,207.44	150,017,110.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,957,834.55	-45,940,100.74
39217	Ном	958,000.00	958,000.00
393	Биет бус хөрөнгө	33,076,458.43	33,019,958.47
39301	Програм хангамж	965,000.00	765,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-536,541.57	-393,041.53
39303	Бусад биет бус хөрөнгө	32,648,000.00	32,648,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	330,995,849.15	1,823,194,244.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	58,277.00	2,762,262.29
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,277.00	2,762,262.29
413	Өглөг	58,277.00	2,762,262.29
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	58,277.00	2,762,262.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	330,937,572.15	1,820,431,982.17
51	Засгийн газрын хувь оролцоо	330,937,572.15	1,820,431,982.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	419,793,425.59	421,793,425.59
51101	Өмч: - төрийн	419,793,425.59	421,793,425.59
512	Хуримтлагдсан үр дүн	270,728,550.18	1,350,442,820.14
51210	Өмнөх үеийн үр дүн	270,728,550.18	-137,051,589.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,487,494,410.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	181,872,696.74	48,195,736.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	330,995,849.15	1,823,194,244.46

2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	559,530,200.00	2,179,020,309.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,787,500.00	1,509,411,509.04
120	Нийтлэг татварын бус орлого	16,787,500.00	1,509,411,509.04
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,787,500.00	1,509,411,509.04
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,787,500.00	1,509,411,509.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	70,667,900.00	125,279,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	472,074,800.00	544,329,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,074,800.00	544,329,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,237,200.00	8,362,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,237,200.00	8,362,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,430,700.00	116,916,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,430,700.00	116,916,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	675,434,848.34	691,525,899.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	544,082,380.22	691,525,899.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,035,892.57	659,808,333.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	319,698,013.00	390,752,221.26
210101	Үндсэн цалин	301,249,669.00	390,752,221.26
210104	Урамшуулал	18,448,344.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,036,773.35	48,372,941.57
210201	Тэтгэврийн даатгал	39,036,773.35	48,372,941.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,977,118.00	104,594,737.00
210301	Гэрэл, цахилгаан	4,090,181.00	4,557,266.00
210302	Түлш, халаалт	48,266,937.00	99,527,471.00
210303	Цэвэр, бохир ус	620,000.00	510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,102,806.00	16,729,270.00
210401	Бичиг хэрэг	1,771,640.00	1,843,770.00
210402	Тээвэр, шатахуун	2,885,000.00	9,446,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,501,666.00	1,595,000.00
210404	Ном, хэвлэл	299,500.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	105,000.00	730,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,540,000.00	3,113,900.00
2105	Нормативт зардал	34,076,890.00	35,944,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	396,300.00	2,854,750.00
210502	Хоол, хүнс	33,494,590.00	33,089,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	186,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,392,000.00	2,440,000.00
210602	Тавилга	392,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,440,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,531,000.00	1,522,000.00
210701	Гадаад албан томилолт	42,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,489,000.00	1,522,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	885,000.00	3,868,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	485,000.00	3,418,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,336,292.22	55,584,413.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,400,000.00	00.00

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,351,100.00	4,821,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,585,192.22	50,763,413.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,046,487.65	31,717,565.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,080,200.00	9,703,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,843,000.00	9,703,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,063,582.00	561,663.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,063,582.00	561,663.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,902,705.65	21,452,302.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,902,705.65	21,452,302.46
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	131,352,468.12	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	131,352,468.12	00.00
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	131,352,468.12	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	115,904,648.34	1,487,494,410.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	115,904,648.34	1,487,494,410.02

2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	542,742,700.00	669,608,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	542,742,700.00	669,608,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	472,074,800.00	544,329,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	472,074,800.00	544,329,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,237,200.00	8,362,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,237,200.00	8,362,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,430,700.00	116,916,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,430,700.00	116,916,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	542,742,700.00	651,930,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,742,700.00	651,930,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,392,812.35	608,538,434.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,967,957.35	390,048,500.00
210101	Үндсэн цалин	275,478,791.35	316,862,718.33
210102	Нэмэгдэл	15,300,547.00	47,820,431.67
210104	Урамшуулал	25,188,619.00	25,365,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,319,431.00	47,372,677.54
210201	Тэтгэврийн даатгал	27,256,429.10	34,333,279.28
210202	Тэтгэмжийн даатгал	7,655,861.90	3,307,776.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,133,407.00	2,410,053.11
210204	Ажилгүйдлийн даатгал	471,904.50	784,633.99
210205	Эрүүл мэндийн даатгал	6,801,828.50	6,536,934.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,867,118.00	104,594,737.00
210301	Гэрэл, цахилгаан	3,527,500.00	4,557,266.00



**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210302	Түлш, халаалт	48,829,618.00	99,527,471.00
210303	Цэвэр, бохир ус	510,000.00	510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,011,506.00	8,636,970.00
210401	Бичиг хэрэг	2,475,040.00	1,152,940.00
210402	Тээвэр, шатахуун	2,885,000.00	2,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,566,466.00	1,319,430.00
210404	Ном, хэвлэл	2,733,500.00	1,590,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	730,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,171,500.00	1,344,600.00
2105	Нормативт зардал	32,366,700.00	28,977,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	321,300.00	612,200.00
210502	Хоол, хүнс	24,710,600.00	27,186,350.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,334,800.00	1,178,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,894,500.00	5,946,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,569,200.00
210602	Тавилга	21,394,500.00	00.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	3,376,800.00
2107	Томилолт, зочны зардал	2,531,000.00	1,522,000.00
210702	Дотоод албан томилолт	2,531,000.00	1,522,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,037,600.00	1,286,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	637,600.00	836,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,397,000.00	20,154,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	7,062,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,397,000.00	13,091,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,349,887.65	43,392,265.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,383,600.00	21,378,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,997,000.00	11,674,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,237,200.00	8,362,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,149,400.00	1,340,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,063,582.00	561,663.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,063,582.00	561,663.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,902,705.65	21,452,302.46
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,902,705.65	21,452,302.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	17,678,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	17,678,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	17,678,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	17,678,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	17,678,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-17,678,100.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	419,793,425.59	231,367,871.67	-201,695,372.36	449,465,924.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	49,495,174.93	49,495,174.93
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	419,793,425.59	231,367,871.67	-152,200,197.43	498,961,099.83
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	-49,495,174.93	00.00	-49,495,174.93
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-118,528,352.75	-118,528,352.75
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	419,793,425.59	181,872,696.74	-270,728,550.18	330,937,572.15
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	419,793,425.59	181,872,696.74	-270,728,550.18	330,937,572.15
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,000,000.00	00.00	133,676,960.30	135,676,960.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	421,793,425.59	181,872,696.74	-137,051,589.88	466,614,532.45
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	133,676,960.30	00.00	-133,676,960.30
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,487,494,410.02	1,487,494,410.02
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	421,793,425.59	48,195,736.44	1,350,442,820.14	1,820,431,982.17

2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	661,246,000.00	639,232,034.54	22,013,965.46	96.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	661,246,000.00	639,232,034.54	22,013,965.46	96.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	643,272,500.00	626,216,534.54	17,055,965.46	97.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390,048,500.00	390,048,500.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	287,633,800.00	316,862,718.33	29,228,918.33	110.2
210102	Нэмэгдэл	48,236,000.00	47,820,431.67	415,568.33	99.1
210104	Урамшуулал	54,178,700.00	25,365,350.00	28,813,350.00	46.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,896,500.00	47,372,677.54	4,523,822.46	91.3
210201	Тэтгэврийн даатгал	36,934,600.00	34,333,279.28	2,601,320.72	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,740,500.00	3,307,776.92	432,723.08	88.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,992,400.00	2,410,053.11	582,346.89	80.5
210204	Ажилгүйдлийн даатгал	748,000.00	784,633.99	-36,633.99	104.9
210205	Эрүүл мэндийн даатгал	7,481,000.00	6,536,934.24	944,065.76	87.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,916,400.00	113,354,737.00	561,663.00	99.5
210301	Гэрэл, цахилгаан	4,857,500.00	4,557,266.00	300,234.00	93.8



**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210302	Түлш, халаалт	108,548,900.00	108,287,471.00	261,429.00	99.8
210303	Цэвэр, бохир ус	510,000.00	510,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	10,240,900.00	6,136,970.00	4,103,930.00	59.9
210401	Бичиг хэрэг	1,154,600.00	1,152,940.00	1,660.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	4,100,000.00	00.00	4,100,000.00	0.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,319,800.00	1,319,430.00	370.00	100.0
210404	Ном, хэвлэл	1,591,900.00	1,590,000.00	1,900.00	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	730,000.00	730,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,344,600.00	1,344,600.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	39,285,100.00	31,477,450.00	7,807,650.00	80.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,235,000.00	1,212,200.00	22,800.00	98.2
210502	Хоол, хүнс	36,871,200.00	29,086,350.00	7,784,850.00	78.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,178,900.00	1,178,900.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,716,400.00	13,326,800.00	389,600.00	97.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,150,000.00	7,150,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	6,566,400.00	6,176,800.00	389,600.00	94.1
2107	Томилолт, зочны зардал	1,524,300.00	1,522,000.00	2,300.00	99.8
210702	Дотоод албан томилолт	1,524,300.00	1,522,000.00	2,300.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,286,500.00	1,286,100.00	400.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	836,500.00	836,100.00	400.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21357900.00	21331300.00	26,600.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,500,000.00	7,500,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,857,900.00	13,831,300.00	26,600.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17973500.00	13015500.00	4,958,000.00	72.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,973,500.00	13,015,500.00	4,958,000.00	72.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,632,700.00	11,674,700.00	4,958,000.00	70.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,340,800.00	1,340,800.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	661,246,000.00	639,232,034.54	22,013,965.46	96.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	544,329,600.00	522,877,297.54	21,452,302.46	96.1
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	544,329,600.00	522,877,297.54	21,452,302.46	96.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,916,400.00	116,354,737.00	561,663.00	99.5
132001	Орон нутгийн төсвөөс	116,916,400.00	116,354,737.00	561,663.00	99.5
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	27	27		
620003	Үйлчлэх ажилтан	6	6		

*Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,362,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,362,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,362,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		8,362,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		8,362,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	8,362,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,362,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал М.Бибиш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав

Аудитыг 2021.02.13-ноос 2021.02.14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021.01.15 ний өдрийн 6 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх ажлыг хэвшүүлж багшийн хөгжлийн төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах.
- “Сайн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, ЗАН, секц, багаараа хамтран нээлттэй, судалгаат, хамтын, зочинтой хичээлүүдийг явуулдаг менежментийг сургууль, цэцэрлэг бүр хэрэгжүүлэх.
- Цэцэрлэг болон сургуулийн нийт сурагчдыг хамруулан хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдын олон талт оюуны чадамжийг хөгжүүлэх зорилгоор математик сэтгэлгээг хөгжүүлэх нэмэлт сургалт, болон англи хэлний сургалтыг цэцэрлэг, сургуулийн наснаас нь сургах туршилтыг чанартай зохион байгуулна.
- Багшийн ажлыг мэдлэг, ур чадвар, сурган хүмүүжүүлэх үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр үнэлж урамшуулдаг болох.
- “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлж, сургалтын байгууллага ёс зүйн зөрчлөөс ангид байхыг эрхэмлэн багш, ажилтан бүр ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа чанд мөрдөнө.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тус байгууллагын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 36349.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 4707.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож 2020.12.05-ны дотор хэрэгжилтийг хүлээн авч тооцон ажилласан байна.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 436651.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8733.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 691525.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 13830.5 мянган төгрөгөөр материаллаг байдлын суурийн дахин тооцсон.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,235.1	71,267.3	27,032.2
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,618.7	12,568.7	10,950.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	42,616.5	58,698.7	16,082.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	286,760.7	1,751,926.9	1,465,166.2
Үндсэн хөрөнгө	411,426.9	1,927,156.5	1,515,729.6
Хуримтлагдсан элэгдэл	(124,666.2)	(175,229.6)	(50,563.4)
Нийт хөрөнгө	330,995.8	1,823,194.2	1,492,198.4
Өр төлбөр	58.3	2,762.3	2,704.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	330,937.6	1,820,432.0	1,489,494.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	330,995.8	1,823,194.2	1,492,198.4

Эх сурвалжийг/ Санхүүгийн тайлангаас авагч

Авлага дансны үлдэгдэл 12568.7 мянган төгрөг болж 9950,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны эцэст сургалтын үйл ажиллагаанд ашиглахаар “Санко Маркетинг Монголиа” ХХК-аас “Ухаалаг самбар” худалдан авахаар мөнгийг шилжүүлсэн, цалингийн урьдчилгааны 1000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58698.7 мянган төгрөг болж 16082.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 13160.0 мянга, эм боох материал 3357.4 мянга, бичиг хэргийн материал 2293.9 мянга, аж ахуйн материал 4389.2 мянга тус тус өссөн, хүнсний материал 7118.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1927156.5 мянган төгрөг болж 1515729.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 17318.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдаж авсан, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1496611.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Аймгийн ИТХ-ын 2020.11.06 ний өдрийн 108 дугаар тогтоолоор ашиглалтгүй байсан 200.0 мянган төгрөгийн программ хангамжийг данснаас хассан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2762.3 мянган төгрөг болж 2704.0 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн өглөг 399.3 мянга, ХАОАТ-ын өглөг 2304.7 мянган төгрөгийн өглөг тус тус өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1820432.0 мянган төгрөг болж 1489494.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн 1487494.4 мянга, засгийн газрын сан 2000.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний данс оны эхэнд 181872.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант оны эцэст 48195.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь урд онуудад акталсан хөрөнгө болон хичээлийн байрны хөрөнгийн дахин үнэлгээг хасаагүйтэй холбоотой байна.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2179020.3 мянган төгрөг болж өмнөх оноос 1619490.1 мянган төгрөгөөр буюу 289.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 1619490.1 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь тусгай зориулалтын санхүүжилт 72254.8 мянга төгрөгөөр нэмэгдсэн урсгал үйл ажиллагааны санхүүжилт 49485.7 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 1492624.0 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого 5125.6 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 691525.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 16091.0 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, байр ашиглахтай холбоотой зардал, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бусад урсгал шилжүүлгийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 688572.4 мянган төгрөгөөр тооцон, суралцагчдын тоог 231, ажиллагсдыг 39 орон тоогоор төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 44343.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 732915.9 мянган төгрөгөөр, суралцагчдын тоог 231, ажиллагсдыг 34 орон тоотой баталсан байна.

Энэ нь цалин, НДШ, тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 732915.9 мянган төгрөгийг батлагдсанаас 3 удаагийн зохицуулалт хийж 71669.9 мянган төгрөгөөр хасаж 661246.0 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 544329.6 мянга, орон нутгийн төсвөөс 116916.4 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 544329.6 мянган, орон нутгийн төсвөөс 116916.4 мянган төгрөгийн нийт 639232.0 мянган төгрөгийг урсгал үйл

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

ажиллагаанд зарцуулж 21452.3 мянган төгрөгийг улсын төсөвт, 561.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 639232.0 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь НДШ-ийн зардлыг 4523.7 мянга, тогтмол зардал 561.7 мянга, хангамжийн материал 4103.9 мянга, нормативт зардал 7807.7 мянга, эд хогшил урсгал засварын зардал 389.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 26.6 мянга, төрөөс иргэдэд олгох бусад тэтгэмж, урамшуулал 4958.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-2 Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр зориулалтаар

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХӨТӨЛБӨР 71802	661,246,000.00	639,232,034.54	22,013,965.46	96.67
АРГА ХЭМЖЭЭ 81834				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	312,427,500.00	310,239,529.44	2,187,970.56	99.30
УРСГАЛ ЗАРДАЛ	312,427,500.00	310,239,529.44	2,187,970.56	99.30
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	312,427,500.00	310,239,529.44	2,187,970.56	99.30
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	248,712,800.00	248,712,800.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,816,200.00	30,687,259.44	2,128,940.56	93.51
Хангамж, бараа материалын зардал	4,724,500.00	4,720,570.00	3,930.00	99.92
Нормативт зардал	1,917,100.00	1,894,300.00	22,800.00	98.81
Эд хогшил, урсгал засварын зардал	10,219,600.00	10,190,000.00	29,600.00	99.71
Томилолт, зочны зардал	1,524,300.00	1,522,000.00	2,300.00	99.85
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,286,500.00	1,286,100.00	400.00	99.97
Бараа үйлчилгээний бусад зардал	11,226,500.00	11,226,500.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 71802				
АРГА ХЭМЖЭЭ 81806				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,558,200.00	78,736,320.41	9,821,879.59	88.91
УРСГАЛ ЗАРДАЛ	88,558,200.00	78,736,320.41	9,821,879.59	88.91
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,558,200.00	78,736,320.41	9,821,879.59	88.91
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	44,323,400.00	44,323,400.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,983,600.00	3,946,570.41	2,037,029.59	65.96
Хангамж, бараа материалын зардал	386,400.00	386,400.00	0.00	100.00
Нормативт зардал	37,368,000.00	29,583,150.00	7,784,850.00	79.17
Эд хогшил, урсгал засварын зардал	496,800.00	496,800.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 71802				
АРГА ХЭМЖЭЭ 81835				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	113,484,200.00	109,379,813.94	4,104,386.06	96.38
УРСГАЛ ЗАРДАЛ	113,484,200.00	109,379,813.94	4,104,386.06	96.38
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,484,200.00	109,379,813.94	4,104,386.06	96.38
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	86,655,700.00	86,655,700.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,698,500.00	11,694,113.94	4,386.06	99.96
Хангамж, бараа материалын зардал	5,130,000.00	1,030,000.00	4,100,000.00	20.08
Бусад бараа үйлчилгээний зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 71802				
АРГА ХЭМЖЭЭ 80101				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,886,200.00	11,506,133.75	380,066.25	96.80
УРСГАЛ ЗАРДАЛ	11,886,200.00	11,506,133.75	380,066.25	96.80
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,886,200.00	11,506,133.75	380,066.25	96.80
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	10,356,600.00	10,356,600.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,398,200.00	1,044,733.75	353,466.25	74.72
Бусад бараа үйлчилгээний зардал	131,400.00	104,800.00	26,600.00	79.76

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

ХӨТӨЛБӨР 71802				
АРГА ХЭМЖЭЭ 80109				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	116,916,400.00	116,354,737.00	561,663.00	99.52
УРСГАЛ ЗАРДАЛ	116,916,400.00	116,354,737.00	561,663.00	99.52
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,916,400.00	116,354,737.00	561,663.00	99.52
Байр ашиглахтай холбоотой зардал	113,916,400.00	113,354,737.00	561,663.00	99.51
Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 71802				
АРГА ХЭМЖЭЭ 80802				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,340,800.00	1,340,800.00	0.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	1,340,800.00	1,340,800.00	0.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,340,800.00	1,340,800.00	0.00	100.00
ХӨТӨЛБӨР 70106				
АРГА ХЭМЖЭЭ 81801				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,632,700.00	11,674,700.00	4,958,000.00	70.19
Бусад урсгал шилжүүлэг	16,632,700.00	11,674,700.00	4,958,000.00	70.19
төрөө иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	16632700	11,674,700.00	4,958,000.00	70.19

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 8362.8 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсныг Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 8362.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд “Шилэн дансны тухай” хуулийн дагуу байршуулбал зохих 151 мэдээллээс 129 мэдээллийг бүрэн байршуулсан, Үүнээс хугацаа хоцорсон 20 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 84324.0 мянга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 61299.0 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 23238.7 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт-3

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	3	0	2
2	Хагас жил	4	4	3	1		
3	Улирал бүр	1	4	4			
4	Сар бүр	3	36	35	1		
5	Тухай бүр	8	96	81	15		
6	Нийт	27	151	129	20	0	2

Эх сурвалжийг/ байгууллагын шилэн данснаас авав/

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 21540.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 10740.0 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 10800.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн ба төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна. Зөвлөмжийн биелэлтийг сургуулийн захирлын 2020.09.21-ний өдрийн 119 дүгээр албан бичгээр ирүүлж биелэлтийг тооцсон байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт.

Хүснэгт-4

/Мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	10740.0	4	10740.0			
Зөвлөмж	2	10800.0	2	10800.0			
Нийт дүн	6	21540.0	6	21540.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 189394.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 133676.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 3116.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 13165.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 39435.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Оны эхэнд 181872.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант оны эцэст 48195.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2015 оноос хойш акталсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, 2019 онд акталсан хичээлийн байрны хөрөнгийн дахин үнэлгээг хасаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 хавсралт Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.44. "Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн руу шилжүүлнэ." гэсэн заалт болон Оршин байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 133676.9 мянган төгрөгийг бууруулж санхүүгийн тайланд залруулга хийлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 55717.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3116.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 13165.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 39435.6 мянган төгрөгийн 6 зөвлөмж тогтоож хүргүүллээ Үүнд:

1. Нярав Ч.Эрдэнэсүрэнгийн данс руу 9 удаагийн гүйлгээгээр 13165.0 мянган төгрөгийн шилжүүлж хөрөнгө, материал, тээврийн хөлсөнд төлсөн байна. Бэлэн мөнгөний зарцуулалтыг хянаж үзэхэд хөрөнгө худалдаж авсан Е-баримт байхгүй, ачаа ачсан тээврийн жолоочид бэлэн мөнгө хүлээлгэж өгсөн баримт байхгүй ХХОАТ-ийн суутгаж аваагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5. "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нярав Ч.Эрдэнэсүрэнгийн хувийн харилцах дансаар дамжсан 13165.0 мянган төгрөгийн 10 хувь болох 1316.5 мянган төгрөгийн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. "Их богдын Ундарга" ХХК руу 2020.03.03-ны өдөр онцгой байдлын шатахууны үнэнд анхан шатны баримтгүй, захирлын гарын үсэггүй төлбөрийн баримтаар сумын төрийн сангийн төлөөлөгч шатахууны гүйлгээг хийсэн байна.

Энэ нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүй хийгдсэн 1800.0 мянган төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

3. Өмнөх оны аудитаар нярвын дансаар дамжуулж 10070.8 мянган төгрөг шилжүүлж бэлнээр авч кассын тайлан гаргаагүй мөн Е баримт байгууллагуудаас авахгүй гүйлгээ хийсэн зөрчил илэрч зөвлөмж өгсөн байхад тайлант онд нярав Ч.Эрдэнэсүрэнгийн хувийн харилцах дансаар 13165.0 мянган төгрөг дамжуулж хөрөнгө худалдаж авсан Е баримт байхгүй, ачаа ачсан тээврийн жолоочид бэлэн мөнгө хүлээлгэж өгсөн баримт байхгүй байна.

Энэ нь Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020.12.09-ны өдрийн А/95 дугаар тушаалын "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1."Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 2.1.10. "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол", Төсвийн байгууллагын үйл ажиллагааны мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.2 Төсвийн байгууллага нь арилжааны банкны төлбөрийн картан дансанд байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай бэлэн мөнгийг төрийн сангаас баталсан хязгаар/ЖМС/-ын дотор шилжүүлэн авч болох бөгөөд гадаад, дотоод албан томилолт, гадаад зочны зардал, тэтгэмж, урамшуулал, шагналыг батлагдсан төсвийн хүрээнд шилжүүлэн авч болно. гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

4.Сургуулийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 08 ний өдрийн А/103 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь хөрөнгийг тоолсон гэх боловч тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 39435.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар анхан шатны баримтгүй ажил гүйлгээ хийдэг, хоол, үдийн цай, халаалтын зардлаас төсөвт зохицуулалт хийлгүй зориулалт бус гүйлгээ хийдэг, нярвын хувийн харилцах дансаар дамжуулж хөрөнгө бэлтгэдэг байдалд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: "Санко Маркетинг Монголиа" ХХК -тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгаж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Дээрх хөрөнгийг аймгийн Боловсрол соёл урлагийн газрын даргын 2020.11.23 ний өдрийн 294 тоот албан бичгийн дагуу аймгийн Засаг даргын 2020.11.27-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/770 дугаар захирамжаар аймаг, сумдын ЕБС-дад "Хичээл практик"-ийн зардлыг 10000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тухайн мөнгөөр худалдан авалтыг хийхээр мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалттай нийцэхгүй байна.

1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

1.3 Өгсөн зөвлөмж: Өмнөх оны авлагыг барагдуулах, нийлүүлэгч ААНБ-аас хөрөнгийг хүлээн авч авлагыг бүрэн барагдуулах, Цаашид төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, өр авлага үүсгэхгүй ажиллах, "Ковид-19" цар тахлын улмаас хэмнэгдэж буй зардлыг үр ашиггүй зарцуулахгүй байж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Удирдлагын дээд болон дотоод хяналт:

2.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 129 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 20 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн бүхий орлогын 1 гүйлгээ 84324 мянга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 61299.0 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа , ажил үйлчилгээний 23238.7 мянган төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.

2.2 Эрсдэл: Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4 " Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсний дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэсэн "Эх бүрдэн" ХХК руу 2020.10.18-ны өдөр шинээр ашиглалтад орсон 240 хүүхдийн сургуулийн зураг төсөвт тусгагдаагүй байсан хувцасны өлгүүрийн өрөө, хяналтын жижүүрийн өрөө, хүлээлгийн коридорын таазны тохижилтыг хийлгүүлэхээр 4000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа" гэж барилга байгууламжийг ашиглалтад оруулж, гэрчилгээ олгосноос хойш захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч болон барилгын үйл ажиллагаанд оролцогч бусад этгээд барилгын хийц, бүтээц, эдлэхүүн, тоног төхөөрөмж, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны ашиглалтын хэвийн нөхцөлийг хариуцан хангах хугацааг" 14 дүгээр зүйлийн 14.3. "Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байх

3.3 Өгсөн зөвлөмж: Шинээр ашиглалтад орсон барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах нэг жилийн хугацаанд засвар үйлчилгээний зардлыг гүйцэтгэгч компаниас гаргуулах

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын түүвэр хийж үзэхэд хүүхдийн хоолны зардалд 46197.5 мянган төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 29086,3 мянган төгрөг зарцуулсан байна. Үүнийг нярвын тайлан хүүхдийн хоолны менютэй тулган шалгахад байрны хүүхдийн хоолны зардалд 13233.5 мянга, урд оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актын 4327.3 мянга, онцгой байдлын шатахуунд 6800.0 мянга, дархлаа дэмжих бүтээгдэхүүнд 4725.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын "Эдийн засгийн ангилал батлах тухай" 55 дугаар тушаалын "Хоол хүнс" ангилалд "Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байх

3.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж, хүүхдийн хоолны зардлыг өөр зардлаас зарцуулж гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоох.

5. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт: Тээвэр шатахууны зардалд 4100.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 9446.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд шатах тослох материалын зарцуулалтыг тулган шалгаж үзэхэд тээвэр шатахууны зардлаас 4100.0 мянга, үдийн цайны зардлаас 5200.0 мянга, багаж техник хэрэгслийн зардлаас 146.0 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.

5.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байх

5.3 Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж зайлшгүй шаардлагатай зардлыг аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүсэлт гаргасны дагуу төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж гүйлгээ хийж байх.

6. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

6.1 Илрүүлэлт: Халаалтын зардлаас зориулалт бусаар 8760.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд 2020.02.06-нд "ЭГО КОНСТРАКШН" ХХК руу 1500.0 мянган төгрөгийн жанамын үнэ, 2020.04.24-нд Гэрэлтүүлэн Констракшн ХХК руу 7260.0 мянган төгрөгийн цэвэр усны нөөцийн савыг тус тус худалдан авсан байна.

6.2 Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх.

6.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг төлөвлөхдөө үндэслэлтэй төлөвлөж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж хэмнэлтийг төсөвт бүрэн төвлөрүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Н.БҮНЧИНСҮРЭН 2021.02.25

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Б.МӨНХБАТ 2021.02.25



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.12.31	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/116/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Жинст сумын Ерөнхий боловсролын сургууль		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Оны эхэнд 181872.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан тайлант оны эцэст 48195.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь 2015 оноос хойш акталсан тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, 2019 онд акталсан хичээлийн байрны хөрөнгийн дахин үнэлгээг хасаагүйтэй холбоотой байна.	133677.0	Санхүүгийн тайланд залруулга хийх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
2	Өмнөх оны аудитаар нярвын дансаар дамжуулж 10070.8 мянган төгрөг шилжүүлж бэлнээр авч кассын тайлан гаргаагүй мөн Е баримт байгууллагуудаас авахгүй гүйлгээ хийсэн зөрчил илэрч зөвлөмж өгсөн байхад тайлант онд нярав Ч.Эрдэнэсүрэнгийн хувийн харилцах дансаар 13165.0 мянган төгрөг дамжуулж хөрөнгө худалдаж авсан Е баримт байхгүй, ачаа ачсан тээврийн жолоочид бэлэн мөнгө хүлээлгэж өгсөн баримт байхгүй байна.	13165.0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
3	Сургуулийн захирлын 2020 оны 12 дугаар сарын 08 ний өдрийн А/103 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь хөрөнгийг тоолсон гэх боловч тооллогын бүртгэлийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо бодсон акт үйлдээгүй байна.		Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
4	Нярав Ч.Эрдэнэсүрэнгийн данс руу 9 удаагийн гүйлгээгээр 13165.0 мянган төгрөгийн шилжүүлж хөрөнгө, материал, тээврийн хөлсөнд төлсөн байна. Бэлэн мөнгөний зарцуулалтыг хянаж үзэхэд хөрөнгө худалдаж авсан Е-баримт байхгүй, ачаа ачсан тээврийн жолоочид бэлэн мөнгө хүлээлгэж өгсөн баримт байхгүй ХХОАТ-ийн суутгаж аваагүй байна.	1316.5	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
5	Их богдын Ундарга" ХХК руу 2020.03.03-ны өдөр онцгой байдлын шатахууны үнэнд анхан шатны баримтгүй, захирлын гарын үсэггүй төлбөрийн баримтаар сумын төрийн сангийн төлөөлөгч шатахууны гүйлгээг хийсэн байна	1800.0	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
6	Сургуулийн төсөвт оны эцэст зохицуулалт хийлгэж "Санко Маркетинг Монголиа" ХХК-аас сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9950,0 мянган төгрөгийг шилжүүлж авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4 дэх заалтыг зөрчсөн байна.	9950.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
7	Сургуулийн барилгын ажлыг гүйцэтгэсэн "Эх бүрдэн" ХХК руу 2020.10.18-ны өдөр шинээр ашиглалтад орсон 240 хүүхдийн сургуулийн зураг төсөвт тусгагдаагүй байсан хувцасны өлгүүрийн өрөө, хяналтын жижүүрийн өрөө, хүлээлгийн коридорын таазны тохижилтыг хийлгүүлэхээр 4000.0 мянган төгрөгийг урсгал засварын зардлаас шилжүүлсэн байна	4000.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
8	Дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас байрны хүүхдийн хоолны зардалд 13233.5 мянга, урд оны санхүүгийн тайлангийн төлбөрт 4327.3 мянга, онцгой байдлын шатахуунд 6800.0 мянга, дархлаа дэмжих бүтээгдэхүүнд 4725.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	11525.5	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

9	Тээвэр шатахууны зардалд 4100.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 9446.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд шатах тослох материалын зарцуулалтыг тулган шалгаж үзэхэд тээвэр шатахууны зардлаас 4100.0 мянга, үдийн цайны зардлаас 5200.0 мянга, багаж техник хэрэгслийн зардлаас 146.0 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.	5200.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
10	Халаалтын зардлаас зориулалт бусаар 8760.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Үүнд 2020.02.06-нд "ЭГО КОНСТРАКШН" ХХК руу 1500.0 мянган төгрөгийн жанамын үнэ, 2020.04.24-нд Гэрэлтүүлэн Констракшн ХХК руу 7260.0 мянган төгрөгийн цэвэр усны нөөцийн савыг тус тус худалдан авсан байна.	8760.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
11	Тайлант хугацаанд оруулбал зохих зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 129 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 20 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн бүхий орлогын 1 гүйлгээ 84324 мянга, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 61299.0 мянга, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа , ажил үйлчилгээний 23238.7 мянган төгрөгийн мэдээллийг тус тус хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	М.Бибиш Б.Чулуундорж
ДҮН		189394.0			

_____оОо_____